



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 7/116.

Улаанбаатар хот

Тушаалын холбогдох хэсгийг
хүчингүй болгох тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13, 11.1.14, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төв аймгийн засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 01/932, 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/1236 тоот албан бичгүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор сонгон шалгаруулалт зарласан Төв аймгийн Баян сумын нутаг 2284.39 гектар бүхий Хүрэн толгой-1 нэртэй СШ 57-6 дугаартай талбай нь Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 20 дугаар зүйлийн 20.1.3, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д заасан чиг үүргийнхээ хүрээнд мөн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газартай давхцаж байгаа тул уг сонгон шалгаруулалт зарласан Хүрэн толгой-1 нэртэй талбайг хүчингүй болгосугай.

2. Тушаалын холбогдох хэсгийг хүчингүй болгосонтой холбогдуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэхийг Сонгон шалгаруулалтын комисс /Д.Батмагнай/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэс баялгийн салбарын асуудал хариуцсан орлогч даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Түвшинжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН